

## ГАРЧИГ

<i>НЭГ. 2022 ОНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ</i>	
<i>ТАНИЛЦУУЛГА.....</i>	<i>3</i>
<i>ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ</i>	
<i>ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....</i>	<i>8</i>
<i>ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ</i>	
<i>БИЕЛЭЛТ.....</i>	<i>10</i>
<i>ДӨРӨВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ</i>	
<i>ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....</i>	<i>10</i>
<i>ТАВ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....</i>	<i>10</i>
<i>ЗУРГАА. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....</i>	<i>10</i>
<i>ДОЛОО. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ.....</i>	<i>15</i>
<i>НАЙМ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН</i>	
<i>ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....</i>	<i>17</i>
<i>ЕС. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ</i>	
<i>НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ</i>	
<i>ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....</i>	<i>17</i>
<i>ДҮГНЭЛТ.....</i>	<i>18</i>

## ХҮСНЭГТИЙН ГАРЧИГ

Хүснэгт 1. Үйлдвэрийн булангийн цэгийн солбицол .....	3
Хүснэгт 2. Ажиллах хүч .....	5
Хүснэгт 3. Техник тоног төхөөрөмжийн жагсаалт .....	7
Хүснэгт 4. Ногоон байгууламжийн төлөвлөгөө .....	10

## ЗУРГИЙН ГАРЧИГ

Зураг 1. Төслийн байршлын зураг .....	4
Зураг 2. Төслийн технологийн схем .....	6
Зураг 3. Үйлдвэрийн зам талбайг услах, шүүрдэж цэвэрлэх ажлын үйл явц .....	9
Зураг 4. Хог хаягдал ачиж тээвэрлэх гэрээ .....	14
Зураг 5. Хөрсний шинжилгээний хариу .....	15
Зураг 6. Усны шинжилгээний хариу .....	16

## НЭГ. 2022 ОНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

<b>Төслийн нэр:</b>	<b>“Бетон зуурмагийн үйлдвэр”</b>
<b>Төсөл хэрэгжүүлэгч:</b>	“БАТ БЭХ РЕМИКОН” ХХК Улсын бүртгэлийн дугаар: 9019020146 Регистрийн дугаар: 5180651 Газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар: 000343752
<b>Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:</b>	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 403 тоот. Утас: 9411-3009

**Төслийн байршил:** “БАТ БЭХ РЕМИКОН” ХХК-ийн “Бетон зуурмагийн үйлдвэр” нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 21-р хорооны нутаг дэвсгэр, Морин /17130/ гудамж, 35 тоотод 1.0 га талбайд үйл ажиллагаа явуулдаг.

2022 онд 78.0 мян.м<sup>3</sup> бетон зуурмаг үйлдвэрлэн хэрэглэгчдэд нийлүүлсэн болно.

*Хүснэгт 1. Үйлдвэрийн булангийн цэгийн солбицол*

№	Газарзүйн солбицол	
1	47° 49' 06.01”	106° 45' 20.71”
2	47° 49' 08.95”	106° 45' 23.91”
3	47° 49' 08.90”	106° 45' 29.14”
4	47° 49' 06.03”	106° 45' 26.15”



Зураг 1. Төслийн байршлын зураг

**Төслийн хүчин чадал**

Үйлдвэр нь цагт 120 м<sup>3</sup> бетон зуурмаг үйлдвэрлэх хүчин чадалтай. Уг үйлдвэр нь М-150-М-500 маркийн хооронд зуурч үйлдвэрлэдэг.

**Ажиллах горим, ажиллах хүч**


Төсөл нь улирлын чанартай явагдах бөгөөд 04-р сарын 01-нээс 10-р сарын 01-нийг хүртэл бетон зуурмаг үйлдвэрлэнэ.

Бетон зуурмагийн үйл ажиллагаа нь хоногт 8 цагаар нэг ээлжийн горимоор 17 хүний бүрэлдэхүүнтэй ажиллана.

Хүснэгт 2. Ажиллах хүч

№	Мэргэжил, албан тушаал	Ажиллах ээлжийн тоо	Орон тоо		Жилд ажиллах сар
			Нэг ээлж	Бүгд	
1	Гүйцэтгэх захирал	1	1	1	7
2	Ерөнхий менежер	1	1	1	7
3	Санхүүгийн менежер	1	1	1	7
4	Кассын нярав	1	1	1	7
5	Нягтлан бодогч	1	1	1	7
6	Борлуулалтын ажилтан	1	1	1	7
7	Оффис ажилтан	1	1	1	7
8	Лабораторийн эрхлэгч	1	1	1	7
9	Лаборант	1	1	1	7
10	Оператор менежер	1	1	1	7
11	Туслах ажилтан	2	1	1	7
12	Миксер жолооч	3	1	1	7
13	Механизмын жолооч	2	1	1	7
	Нийт	17			

*Төслийн технологийн схем*



*Зураг 2. Төслийн технологийн схем*

**Техник тоног төхөөрөмж**

Хүснэгт 3. Техник тоног төхөөрөмжийн жагсаалт

№	Техник, тоног төхөөрөмж, ажлын багаж хэрэгслийн нэр	Тоо ширхэг	Хүчин чадал	Эдэлгээний чанар, хэдэн оноос ашиглаж байгаа	Эх үүсвэр /хувийн, түрээсэлдэг/
<b>А</b>	<b>Үйлдвэрийн тоног төхөөрөмж</b>				
1	Үйлдвэрийн төхөөрөмж	1	120м <sup>3</sup> /цаг		Хувийн
2	Дүүргэгчийн тэжээх бункер	3	6м <sup>3</sup>		Хувийн
3	Элс, хайрга тугнах бункер	3	3000кг		Хувийн
4	Налуу туузан дамжуулагч	1			Хувийн
5	Шигшүүр	1			Хувийн
6	Налуу туузан дамжуулагч	1			Хувийн
7	Хоёр голтой зуурагч	1	2м <sup>3</sup> /цаг		Хувийн
8	Цементний завсрын бункер	1	3м <sup>3</sup>		Хувийн
9	Цементний тугнуур	1	1200кг		Хувийн
10	Усны танк	1	4м <sup>3</sup>		Хувийн
11	Нэмэлт бодисын танк	1	7000л		Хувийн
12	Нэмэлт бодисын танк	2	1000л		Хувийн
13	Усны тугнуур	1	500л		Хувийн
14	Нэмэлтийн тугнуур	1	100кг		Хувийн
15	Дүүргэгчийн завсрын бункер	1	3,25м <sup>3</sup>		Хувийн
16	Усны насос	1	800л/мин		Хувийн
17	Компрессор	1			Хувийн
18	Зуурагч бункер	1	3.25 м <sup>3</sup>		Хувийн
19	Цементний лифт	1			Хувийн
20	Цементний силос	2	200 тн		Хувийн
21	Цементний силос	1	350 тн		Хувийн
22	Шурган зөөгүүр	1	80 тн/цаг		Хувийн
<b>Г</b>	<b>Хөдөлмөр хамгааллын багаж хэрэгсэл</b>				
1	Хамгаалалтын каск	20		Сайн	Хувийн
2	Гагнуурын иж бүрэн хувцас,	5		Сайн	Хувийн
3	хэрэглэл			Сайн	Хувийн
4	Өндрийн бүс	10		Сайн	Хувийн
5	Хүрз	20		Сайн	Хувийн
6	Жоотуу	15		Сайн	Хувийн
7	Лантуу	10		Сайн	Хувийн
8	Лоом	10		Сайн	Хувийн
9	Шонгийн дөрөө	10		Сайн	Хувийн
	Анхны тусламжийн цүнх	20			

## ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хугацаа ба давтамж	Зардал, мян.төг	Төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байдал
<b>Агаар орчин</b>				
<b>Тоосжилт үүсэх</b>	Тоосжилтын хяналтыг тоосжилт үүсэх эх үүсвэрүүд болон ажлын байранд тогтмол хийж, ихэссэн үед нь холбогдох арга хэмжээ авч байх	Төсөл хэрэгжих хугацаанд	300.0	Тоосжилт бууруулах арга хэмжээг хуваарийн дагуу тогтмол хэрэгжүүлж, үйлдвэрийн зам талбайг услах, шүүрдэж цэвэрлэх ажлыг зохион байгуулсан.
	Түүхий эд тээвэрлэхдээ асгарах, тоосрохоос хамгаалсан хучлагатай байх	Төсөл хэрэгжих хугацаанд	Үйл ажиллагааны зардлаас	Түүхий эд тээвэрлэж буй машинуудад тоосжилтоос сэргийлэх хучлагатай байх шаардлага тавьж хэрэгжүүлсэн.
	Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүд оношлогоог тогтмол хийлгэх	Төсөл хэрэгжих хугацаанд	500.0	Автомашинуы үзлэг оношилгоог хуваарийн дагуу хийж гүйцэтгэсэн.
<b>Хөрс, ургамал</b>				
<b>Ажилчдын оффис, үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдал нь хөрс бохирдуулах</b>	Хог хаягдлыг тухай бүрт нь ангилан зайлуулах арга хэмжээ авах	Төсөл хэрэгжих хугацаанд	Хог хаягдлын зардалд тусгагдсан.	Хог хаягдлын гэрээг байгуулж, гэрээний дагуу тээвэрлүүлсэн.
<b>Бусад асуудлаар</b>				
<b>Байгаль орчны хууль тогтоомж, төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн биелэлт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, стандартын хэрэгжилтийг хянах</b>	Байгаль орчны аудит хийлгэж Аудитын дүгнэлт зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлнэ.	Аудитыг төслийн 2 дахь жилээс хийлгэх	Байгаль орчны аудитын төлөвлөгөөнд тусгасан.	Байгаль орчны аудит хийх мэргэжлийн байгууллагатай холбогдож гэрээ байгуулах, аудит хийх ажлын талаар санал солилцсон. 12-р сард багтаан аудитын дүгнэлт гаргуулахаар ажиллаж байна.
<b>Сонирхогч талуудын оролцоог хангах</b>	БОННУ тайлан болон БОМТ-г Орон нутгийн холбогдох байгууллагууд, иргэдэд тайлагнах ажил зохион байгуулах	Жилд 1-2 удаа	Үйл ажиллагааны зардлаар	БОМТ-ний хэрэгжилтийн тайланг НБОГ, БОАЖЯ-ны цахим системд цахимаар илгээж, НБОГ-т хэвлэж хүргүүлсэн.





*Зураг 3. Үйлдвэрийн зам талбайг услах, шүүрдэж цэвэрлэх ажлын үйл явц*

## ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 4. Ногоон байгууламжийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Төлөвлөгөөний биелэлт
1	Ногоон байгууламжийн арчилгаа, тордолгоо	Ногоон байгууламжийн усалгаа	Үйлдвэрийн талбайн ногоон байгууламж	Ногоон байгууламжийн арчлалт, усалгааны ажлыг тогтмол хийж гүйцэтгэсэн.

## ДӨРӨВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


“Бат бэх ремикон” ХХК-ны үйлдвэрийн талбайд палеонтологийн олдворын ул мөр ажиглагдаагүй байна. Түүнчлэн археологийн дурсгал илрээгүй байна.

## ТАВ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Үйлдвэрт бетон зуурмагийн нэмэлт бодис ашигладаг бөгөөд уг бодисыг “Топ микс трейд” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу худалдан авдаг. Уг гэрээгээр худалдан авсан нэмэлт бодисын сав баглаа боодлыг нийлүүлэгч талд хүлээлгэн өгч химийн эрсдэлгүй ажилласан.

## ЗУРГАА. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Үйлдвэрийн үйл ажиллагаанаас технологийн хаягдал үүсдэггүй бөгөөд ахуйн хог хаягдлыг ХУД-ийн “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-тай байгуулсан гэрээний дагуу сар бүр тээвэрлүүлж ажилласан. /Хог хаягдлын гэрээг хавсаргав./



ХОГ ХАЯГДАЛ АЧИЖ, ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

### Дугаар 21-21/13

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Нэг талаас 5673461 тоот регистрийн дугаартай Хан-Уул дүүргийн “Тохижилт үйлчилгээний Төв” ОНӨААТҮГ (цаашид Гүйцэтгэгч гэх), нөгөө талаас 5180651 тоот регистрийн дугаартай, Хан-Уул дүүргийн 21-р хорооны нутаг дэвсгэрт байрлах БЕТОН ЗУУРМАГИЙН ҮЙЛДВЭР чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг БАТ БЭХ РЕМИКОН ГХӨХХК (цаашид Захиалагч гэх) нар доорхи нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.
- 1.2 Энэхүү гэрээ нь 2022 оны 04 сарын 01 -ны өдрөөс 2023 оны 03 сарын 31-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 1.3 “Хог хаягдлын тухай” хуулийн хүрээнд ХУД-ийн нутаг дэвсгэрийн орон сууц, гэр хорооллын айл өрх, ААН байгууллага болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг тээвэрлэх, мөн нийтийн эзэмшлийн зам талбайд үүссэн хог хаягдлыг тээвэрлэх, түүнтэй холбогдон гарсан төлбөр тооцооны асуудлыг шийдвэрлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.
- 1.4 Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2013 оны 09-р сарын 26-ны өдрийн 12/45 дугаар тогтоолоор Хог тээврийн үйлчилгээний хураамжид НӨАТ (нэмэгдсэн өртгийн албан татвар)-ыг тооцоогүй болно.
- 1.5 Хан-Уул дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2013 оны 04-р сарын 18-ны өдрийн А/29 тоот тогтоолын дагуу гэрээний үнийн дүнг хоёр тал харилцан тохиролцон тогтоосон болно.

### Хоёр. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 2.1 Гүйцэтгэгч нь захиалагчтай байгуулсан гэрээнд заасан хуваарийн дагуу ААН байгууллага, орон сууцны бункерийн хог хаягдлыг саадгүй ачиж тээвэрлэх үүрэгтэй.
- 2.2 Тээвэрлэлт саатсанаас хог хаягдал хуримтлагдсан бол графикт зааснаас бусад цагаар нэмэгдэл хүч зохион байгуулан ачуулах арга хэмжээг авна.
- 2.3 Айл өрхөөс гарч буй ахуйн хогийг тогтмол цагт цуглуулах, мөн барилга барих, буулгах, засварлах тохиолдолд иргэн, аж ахуйн нэгжийн хог хаягдлын төлбөрийг төлүүлсний дараа тээвэрлэнэ.
- 2.4 Хог хаягдлыг тээвэрлэх аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан, битүүмжилсэн зориулалтын тээврийн хэрэгсэлтэй байх.
- 2.5 Гүйцэтгэгч нь ажил үйлчилгээ үзүүлсний төлбөрийг ААН, байгууллага болон иргэд, захиалагч байгууллагуудаас шаардах эрхтэй.
- 2.6 Захиалагч тогтоосон хугацаанд төлбөрөө барагдуулаагүй тохиолдолд хог хаягдлыг ачиж тээвэрлэхгүй байх эрхтэй.

002212

## 2.7 Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх үүрэг.

### Гурав. Захиалагчийн эрх, үүрэг

- 3.1 Захиалагч тал “Хог хаягдлын тухай (шинэчилсэн найруулга)” хуулийг мөрдөж ажиллана.
- 3.2 Тухайн ААН, байгууллага, барилга байгууламжаас гарсан хог хаягдлыг зөвхөн тогтоосон хогийн цэг буюу бункерт хийж ачуулах үүрэгтэй.
- 3.3 Тухайн ААН, байгууллага өөрийн талбай (хашаа)-аас гадагш 50 метрийн зай дахь талбайн цэвэрлэгээг хариуцах үүрэгтэй. Цас орж, мөс тогтсон мөн бусад байдлаар бохирдсон тохиолдолд тухайн талбайн цэвэрлэгээг байнга хийж гарах хог хаягдлыг тээвэрлүүлж байна.
- 3.4 Захиалагч тал нь гэрээний 3.2-д заагдсан үүргийг биелүүлээгүй улмаас аливаа ААНБ, иргэнд учирсан хохирлыг Захиалагч тал бүрэн хариуцна.
- 3.5 Хог хаягдлын төлбөрийг сар бүрийн 25-нд Хан-Уул Дүүргийн Татварын Хэлтэс болон [itax.mta.mn](http://itax.mta.mn) сайтаас код авч тушаана.
- 3.6 ААН, байгууллагын барилга байгууламжид засвар хийсэнтэй холбогдон гарсан барилгын болон бусад хог хаягдлыг тухай бүрд нь дуудлага өгч буюу захиалгаар тээвэрлүүлэх үүрэг хүлээх бөгөөд хогны хэмжээнээс хамааран нэмэлт төлбөр төлж хариуцсан албан тушаалтантай хамтарч ажиллана.
- 3.7 Хог агуулах зориулалтын савыг өөрийн хөрөнгөөр шийдвэрлэх бөгөөд хог ачихад саад учруулахгүй газар байрлуулж, машин чөлөөтэй орж гарах нөхцөлийг хангана.
- 3.8 Хогийн сав, бункерийн орчимд машин тэрэг тавиулсны улмаас хог ачих боломжгүй болж хог тээвэрлэх автомашин буцах, хугацаа алдсан тохиолдолд холбогдон гарах хариуцлагыг Захиалагч хүлээнэ.
- 3.9 Өөрийн эзэмшил, өмчлөлийн барилгаа барих, буулгах, засварлах тохиолдолд гарах хог хаягдлыг хаях талаар гүйцэтгэгч талтай урьдчилан гэрээ байгуулан зохих төлбөрийг төлнө.
- 3.10 Хог хаягдал гаргасны төлбөрийг хугацаанд нь бүрэн төлөх үүрэгтэй.
- 3.11 Зориулалтын цэгээс бусад газарт хог хаягдал хаяхгүй байх.
- 3.12 Хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдлэгийг ажилтандаа эзэмшүүлж, аюулгүй ажиллагааны шаардлагыг ханган ажиллах.
- 3.13 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага орчны газрынхаа хог хаягдлыг цэвэрлэх болон хог хаягдлыг зайлуулах олон нийтийг хамарсан ажилд оролцох үүрэгтэй.
- 3.14 Гүйцэтгэгчээс ажил үүргээ тогтоосон хугацаанд гүйцэтгэхийг шаардах эрхтэй.
- 3.15 Дүүрэг болон бусад байгууллага, албан тушаалтнаас зарласан уралдаан, аянд идэвхитэй оролцож тодорхой үр дүн үзүүлсэн бол шагнал урамшуулал хүртэх эрхтэй.
- 3.16 Гүйцэтгэгч ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд төлбөр төлөхгүй байх эрхтэй.
- 3.17 Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх үүргийг эдэлнэ.

### Дөрөв. Төлбөр тооцоо, үнэлгээ

- 4.1 Гэрээт хугацаанд рейс захиалгаар иргэн, ААНБ-ийн бункерийн хог, хаягдлыг ачиж тээвэрлэнэ.
- 4.2 Хог тээвэрлэсний төлбөр нь ХУД-ийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас тогтоосон тарифын дагуу харилцан адилгүй байх бөгөөд тухайн байгууллагын хог тээвэрлэлтийн төлбөр дээрх тогтоолд заасны дагуу сард ..... улиралд ..... жилд ..... төгрөг байна.

- 4.3 Тухайн байгууллагын хог тээвэрлэлтийн төлбөр дээрх тогтоолд заасны дагуу Орон сууц, ААН, хувь хүний захиалгаар хог тээвэрлэлт хийхэд гарах төлбөр:
- |                               |                        |                    |
|-------------------------------|------------------------|--------------------|
| 6-8 тн шахдаг автомашин       | - Ахуйн хог хаягдал    | -150,000.00 төгрөг |
| 4 тн шахдаг авто машин        | - Ахуйн хог хаягдал    | - 85,000.00 төгрөг |
| 4 тн задгай тэвштэй автомашин | - Ахуйн хог хаягдал    | - 85,000.00 төгрөг |
| 4 тн задгай тэвштэй автомашин | - Барилгын хог хаягдал | - 95,000.00 төгрөг |
- 4.4 “Хог хаягдлын тухай” хууль, бусад эрх зүйн актын өөрчлөлт болон зах зээлийн үнийн интервалаас хамаарч үйлчилгээний үнийн тарифт өөрчлөлт оруулж болно.
- 4.5 Хог тээвэрлэлтийн тарифт өөрчлөлт орсон тохиолдолд талуудын төлөөлөл тохиролцон гэрээнд нэмэлт оруулж мөрдөнө. Хэрэв хатуу хог хаягдал болон барилгын засвараас гарсан чулуу, мод, шорооны хог хаягдлыг тээвэрлүүлэх тохиолдолд нэмэлт тарифыг мөрдөх бөгөөд төлбөрийг төлсний дараа гүйцэтгэгч тээвэрлэнэ.
- 4.6 Үйл ажиллагааны онцлогоос хамаарсан хог хаягдлын тээвэрлэлтийг өвөл, зуны батлагдсан графикайн дагуу төлбөр төлөгдсөний дараа тээвэрлэнэ.
- 4.7 Хог тээвэрлэлтийн төлбөрийг ААН, албан байгууллага, үйлчилгээний газрууд нь гэрээний 3.3-д заасан хугацаанд бүрэн төлж барагдуулна. Төлбөрийг хожимдуулсан тохиолдолд хоног тутам 0,5%-ийн алданги төлнө.

#### Тав. Хамтран хүлээх хариуцлага

- 5.1 Талууд энэхүү гэрээ зөрчигдөөгүй тохиолдолд дангаараа гэрээг цуцлах эрхгүй.
- 5.2 Талууд аливаа маргаан, үл ойлголцлыг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд шаардлагатай бол холбогдох хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.
- 5.3 Нийслэл дүүргээс зохион байгуулах их цэвэрлэгээний ажилд дайчлагдан ажиллах үед хог ачилтын хуваарь 1 өдрөөр хойш шилжих асуудал гарч болно. Үүнийг тухайн ААН, байгууллагад урьдчилан мэдэгдэх бөгөөд төлбөр төлөлтөнд ямар нэгэн өөрчлөлт орохгүй.

#### Зургаа. Торгуулиас чөлөөлөгдөх нөхцөл

- 6.1 Байгаль, цаг уурын онц ноцтой үзэгдэл тохиолдох, хүндэтгэх шалтгаанаар авто зам хаагдсаны улмаас хог ачих боломжгүй болсон.
- 6.2 Удирдах, дээд байгууллагын шийдвэрээр автомашиныг өөр ажилд дайчилсан тохиолдолд энэхүү гэрээний 5.2 дахь заалт хамаарахгүй.

#### Долоо. Бусад

- 7.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.
- 7.2 Гэрээнд тусгагдаагүй боловч нэмж оруулах, гэрээнд өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

#### Найм. Нэмэлт өөрчлөлт

20 ..... оны ..... сарын ..... –ний өдөр талууд харилцан тохиролцож энэхүү гэрээнд дараах нэмэлт өөрчлөлтийг оруулав.

.....  
.....  
.....

002212

### Ес. Гэрээний сунгалт

9.1 Гэрээний хугацаа дуусаж, талууд гэрээг цуцлах талаар албан бичгээр санал гаргаагүй бол гэрээг анх байгуулагдсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

9.1.1 Энэхүү гэрээг 20 ..... оны ..... сарын ..... өдрөөс 20 ..... оны ..... сарын ..... өдөр хүртэл талууд харилцан тохиролцож сунгалт хийсэн болно.

Гэрээ сунгасан: \_\_\_\_\_

Гэрээ сунгасан: \_\_\_\_\_

Тайлбар: \_\_\_\_\_

9.1.2 Энэхүү гэрээг 20 ..... оны ..... сарын ..... өдрөөс 20 ..... оны ..... сарын ..... өдөр хүртэл талууд харилцан тохиролцож сунгалт хийсэн болно.

Гэрээ сунгасан: \_\_\_\_\_

Гэрээ сунгасан: \_\_\_\_\_

Тайлбар: \_\_\_\_\_

### Арав. Гэрээ байгуулсан талууд

#### ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛ:

ХУД-ИЙН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ  
ОНӨААТҮГ-ЫН ХОРОО ХАРИУЦСАН  
ХЯНАЛТЫН АХЛАХ АЖИЛТАН

.......... Б.БАТЦЭЦЭГ

Утас: 98111776, 80805479

Тээвэрлэлтийн захиалга өгөх, санал гомдлын  
утас: 95071965

#### ЗАХИАЛАГЧ ТАЛ:

БАТ БЭХ РЕМИКОН ГХОХХК-ИЙН  
БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР

.......... Б.АЗЖАРГАЛ

Утас: 94113009, 99232436

Хаяг: ХУД, 21-р хороо, Морин 17130-35  
тоот

Зураг 4. Хог хаягдал ачиж тээвэрлэх гэрээ



## ДОЛОО. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

ОХШХ-ийн хүрээнд үйлдвэрийн талбай орчмоос агаарын чанарын болон хөрсний бохирдлын дээжийг жил бүр авч шинжлүүлж байна.



**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ  
ГАЗАРЗҮЙ ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН  
ХӨРСНИЙ ЛАБОРАТОРИ**

Хаяг: Монгол улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг,  
7-р хороо, Эрхүүгийн гудамж, 11-р хороолол  
Утас: +976 99141955  
E-mail: soillab.IGG@gmail.com

### Хөрсний задлан шинжилгээний дүн

Дээж авсан газрын нэр: ХУД, 21-р хороо, 17130-35 тоот, 1-р үйлдвэр  
Дээж шинжлүүлсэн байгуулага, хувь хүн: "Бат бэх ремикон" ХХК  
Шинжилгээ хийсэн огноо: 2022 он 08 сар 26

### Хөрсний химийн үндсэн шинж

№	Дээжний дугаар	Гүн, см	pH <sub>H2O</sub> (1:5)	CaCO <sub>3</sub> %	Ялзмаг %	EC <sub>2.5</sub> dS/m	Хөдөлгөөнт, мг/100г	
							P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
1	Дээж-1	өнгөн	7.63	4.0	1.488	0.430	1.05	14.2

### Хөрсний механик бүрэлдэхүүн

№	Дээжний дугаар	Гүн, см	Ширхэгийн хэмжээ, % (мм-ээр)		
			Элс (2-0.05мм)	Тоос (0.05-0.002мм)	Шавар (< 0.002мм)
1	Дээж-1	өнгөн	79.0	11.7	9.3

### Товч дүгнэлт:

Хөрс нь сул шүлтлэг урвалын орчинтой, дунд зэрэг карбонатлаг, ялзмагийн агууламжаар бага зэрэг, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор болон калийн хангамжаар бага зэрэг, механик бүрэлдэхүүн элсэрхэг. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин бага.

### Шинжилгээний арга

pH, EC-MNS ISO 10390:2001- Ионометр, кондуктометр  
CaCO<sub>3</sub>-Кальциметр (10% HCl)  
Ялзмаг-Тюрин (Walkley & Black)  
Хөдөлгөөнт фосфор, кали-Спектрофотометр, дөлөн фотометр-Мачигин (1% (NH<sub>4</sub>)<sub>2</sub>CO<sub>3</sub>)  
Хөрсний механик бүрэлдэхүүн-Гидрометрийн арга

Хөрсний лабораторийн эрхлэгч, доктор (Ph.D)  Х.Золжаргал



Зураг 5. Хөрсний шинжилгээний хариу



ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ  
ГАЗАРЗҮЙ-ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН  
УСНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Усны химийн шинжилгээний тодорхойлолт

Шинжилгээ хийсэн: 2022 оны 04 сарын 01 өдөр

Сорьц авсан газрын нэр: Хан-Уул дүүрэг, 21-р хороо, Морин  
11730-35 тоот

Сорьц шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: "Бат Бэх Ремикон" ХХК

Солбицлол: X=  
Y=

Гүн: м  
Ундарга:

Уст цэгийн төрөл ба дугаар: Худаг

Тодорхойлсон нь:

Анион	1дм <sup>3</sup> -д байгаа			Катион	1дм <sup>3</sup> -д байгаа		
	мг	мг-экв	мг-экв%		мг	мг-экв	мг-экв%
Cl <sup>-</sup>	14.9	0.42	7.2	Na <sup>+</sup> +K <sup>+</sup>	112.3	4.88	83.3
SO <sub>4</sub> <sup>-</sup>	7.0	0.15	2.5	Ca <sup>++</sup>	10.8	0.54	9.2
NO <sub>2</sub> <sup>-</sup>	0.0	0.00	0.0	Mg <sup>++</sup>	5.4	0.44	7.5
NO <sub>3</sub> <sup>-</sup>	0.0	0.00	0.0	NH <sub>4</sub> <sup>+</sup>	0.0	0.00	0.0
CO <sub>3</sub> <sup>-</sup>	0.0	0.00	0.0	Fe <sup>++</sup>	0.0	0.00	0.0
HCO <sub>3</sub> <sup>-</sup>	323.3	5.30	90.4	Fe <sup>+++</sup>	0.0	0.00	0.0
Дүн	345.2	5.87	100.0	Дүн	128.5	5.87	100.0

HCO<sub>3</sub><sup>-</sup> ийн хагасыг хассан анион катионуудын  
нийлбэр: 312.1 мг/дм<sup>3</sup>

Анион катионуудын  
нийлбэр: 473.8 мг/дм<sup>3</sup>

Ерөнхий хатуулаг 0.98 мг-экв/дм<sup>3</sup>  
рН: 7.59

ЕС: 520 μS/cm  
TDS: 288 ppm

Исэлдэх чанар: 2.08 мг/дм<sup>3</sup>

Физик шинж чанар

Тунгалаг: 30 см  
Өнгө: үгүй

Үнэр: үгүй  
Амт: \*\*\*

Тунадас: үгүй  
Булингаршил: 0.08 NTU

HCO<sub>3</sub><sup>-</sup>90

Усны найрлагын томъёо: M<sub>0.47</sub>

Na<sup>+</sup>+K<sup>+</sup>83

Дүгнэлт

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, натрийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, маш зөөлөн ус байна. Шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүд нь "Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018" стандартын шаардлага хангаж байна.

Жич: Энэхүү уст цэгээс сорьц авах үйл явцыг шинжлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно.

Хийсэн: Химич, ЭШДА: Магистр (M.Sc)  /Д.Гэрэлт-Од/

Шинжилгээг

Хянасан: Лабораторийн эрхлэгч: Доктор (Ph.D)  /Б.Одсүрэн/

Зураг 6. Усны шинжилгээний хариу



## НАЙМ. УДИРДАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Төлөвлөлтийг хэрэгжүүлсэн байдал
Энэхүү тайлангийн сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлэх	-
Ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулж, хамруулах	Ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч ажилласан
Ажиллагсдыг улиралд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах.	Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан
Ажиллагсдыг тоосноос хамгаалах хошуувч, хувцас хэрэгслээр хангах	Ажиллагсдыг тоосноос хамгаалах хошуувч, хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажилласан.

## ЕС. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлсэн болно.

## ДҮГНЭЛТ

Манай компани нь 2022 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Тоосжилт ихтэй үед тоосжилт үүсэх эх үүсвэрүүдийг тогтмол хийж байсан.
- ✓ Хог хаягдлын гэрээ байгуулж, гэрээний дагуу тээвэрлүүлж байсан.
- ✓ Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажилласан.
- ✓ Үйлдвэр орчмын ногоон байгууламжийн арчилгаа, усалгааг тогтмол хийж гүйцэтгэсэн.
- ✓ Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд агаар, хөрсний шинжилгээ авч лабораторид шинжлүүлсэн.

2022 онд цементийн үнийн өсөлт болон зах зээлийн эрэлт нэмэгдсэнээр аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа хэвийн үргэлжлэхэд хүндрэлтэй байсан бөгөөд уг нөхцөл байдлын улмаас манай компани төлөвлөгөөндөө хүрч ажиллаж чадаагүй боловч байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр хийгдэх ёстой ажлуудыг цаг тухайд нь хийж гүйцэтгэхийг хичээн ажилласан болно.